



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс:976-7054 3179  
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АЙМГИЙН  
АРДЧИЛСАН НАМД

2020.08.10 № 209  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

“Ардчилсан намын Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3. дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Ардчилсан намын мөрийн хөтөлбөр /.....хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт ..... хуудаатай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

D:\2020\Alban toot.doc

9780/0319



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН  
НАМЫН “ЧОЙР ХОТ ХӨГЖЛИЙН БОДОГО”  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 он

000000001

*Handwritten signatures and marks*





Говьсүмбэр аймгийн Ардчилсан нам 2020 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрөө “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”, “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Ардчилсан намын үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр болон бусад холбогдох хууль, дүрэмд нийцүүлэн боловсрууллаа.

Бид 2012-2016 онуудад Орон нутгийн сонгуулиар “Монгол хүн-2020” хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилтуудаа бүрэн хэрэгжүүлсэн. Энэ удаагийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь бидний өмнө хийсэн ажлын үргэлжлэл болох учиртай.

Иймээс 2020-2024 он хүртэл Говьсүмбэр аймгийг Улсын жишигт хүрсэн хот болгох түүхэн ач холбогдол бүхий “Чойр хот хөгжлийн бодлого” мөрийн хөтөлбөрийг дараах томоохон төслүүдэд суурилан 4 зорилт, 91 арга хэмжээнд боловсрууллаа.

000000002



## **НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ**

- 1.1. Өрсөлдөх чадвартай боловсрол
- 1.2. Эрүүл мэндийн төгс үйлчилгээ
- 1.3. Хүн амын хөгжил
  - Хүн амын өсөлт
  - Өрх гэр бүл
  - Нийгмийн хамгаалал
- 1.4. Соёл, урлаг, спорт

## **ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ**

- 2.1. Өсөлтийн бодлого
  - Жижиг дунд бизнес
  - Сангийн бодлого
  - Татварын бодлого
  - Хөдөлмөрийн зах зээл
  - Аж үйлдвэрлэлийн салбар
  - Эрдэс баялгийн салбар
  - Дэд бүтэц
  - Эрчим хүч
  - Шинжлэх ухаан, технологи, мэдээлэл, харилцаа
  - Барилгын салбар
  - Аялал жуулчлал
  - Хүнсний үйлдвэрлэл

## **ГУРАВ. ЭЗЭН ГОВЬСҮМБЭР**

- 3.1. Хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжил
  - Бүсчилсэн хөгжил
- 3.2. Орон нутгийн хөгжил
  - Иргэдийн оролцоотой “Шинэ сум” төсөл
  - Чинээлэг малчин” хөтөлбөр
- 3.3. Мал аж ахуй
- 3.4. Газар тариалан
- 3.5. Чойр хотын хөгжил
  - Чойр хот

000000003  
*[Handwritten signatures and marks]*



## **ДӨРӨВ. АЮУЛГҮЙ АМГАЛАН ГОВЬСҮМБЭР**

4.1. Батлан хамгаалах бодлого

4.2. Хүрээлэн буй орчин, ногоон хөгжил

- Экоосистемийн тэнцвэртэй байдал

- Байгаль орчны тогтвортой хөгжил

000000004

*Handwritten signatures and initials*





## **НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ**

### **1.1. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БОЛОВСРОЛ**

1.1.1. Боловсролын салбар Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтын анги танхим тоног төхөөрөмжийн бааз суурийг түшиглэн Их дээд сургуулиудын магистер докторын сургалтыг орон нутагт зохион байгуулах.

1.1.2. Ар гэр нь санхүүгийн боломж муутай сурлага сайтай сурагчидтай гэрээ байгуулан Их дээд сургуульд суралцах боломжийг бүрдүүлж сурсан мэдснээ орон нутгийн хөгжилд зориулах чадварлаг боловсон хүчин бэлтгэх

1.1.3. Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх, үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох "Зөв Монгол хүүхэд" хөтөлбөрийг сэргээн орон нутагтаа хэрэгжүүлэх.

1.1.4. Цэцэрлэг, сургуулийн нэг ангийн хүүхдийн тоог 30-аас хэтрүүлэхгүй байх стандартыг хэрэгжүүлнэ.

1.1.5. Малчин өрхийн сургуулийн өмнөх насны хүүхдийг гэр цэцэрлэгт хамруулах сургалтын тогтолцоог бүрдүүлнэ.

1.1.6. Бүх оюутныг сургалтын зээл авах тэгш боломжоор хангана.

1.1.7. Мэргэжлийн боловсролын сургуулиудад хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцсэн нарийн мэргэжлийн шинэ ангиудыг нээж, сургалтын хөтөлбөрийг шинэчилнэ.

1.1.8. Багш нарын мэдлэг, ур чадварыг тухай бүрд нь дээшлүүлж, давтан сургах "Чадварлаг багш" хөтөлбөрийг боловсруулах хэрэгжүүлж, Багш нарын нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх

1.1.9. Тусгай хэрэгцээт (хөгжлийн бэрхшээлтэй) иргэдтэй ажиллах мэргэжилтэн, дохионы хэлний орчуулагч, тусгай сургуулийн багш, мэргэжилтнүүдийг бэлтгэх төлөвлөгөөт арга хэмжээнүүдийг авч, нийгмийн баталгааг нь эрс дээшлүүлнэ.

### **1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨГС ҮЙЛЧИЛГЭЭ**

1.2.1. Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулж, иргэд эрүүл мэндийн шалтгаанаар санхүүгийн эрсдэлд орохгүй байхаар эрүүл мэндийн даатгалын цахим тогтолцоог түргэн шуурхай болгох.

1.2.2. Салбарын хүний нөөцийн сургалт, чанар хүртээмж, төлөвлөлтийг шинэ шатанд гаргаж, нийгмийн асуудлыг цогцоор шийдвэрлэнэ.

1.2.3. Аймгийн нэгдсэн эмнэлгийн Хорт хавдрын оношилгоо, эмчилгээний иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангах.

000000005  
*PhyS* *PhyS* *PhyS*



1.2.4. Амиа хорлолтын шалтгаан сэтгэл гутралын өвчлөл, хар тамхи, мансуурах бодист донтох, хамаарлын болон бусад сэтгэцийн эмгэг өвчнийг эрт илрүүлж, эмчлэх, нөхөн сэргээх эмчилгээ үйлчилгээг сайжруулах.

1.2.5. Эрүүл мэндийн салбарын боловсон хүчний хангалт, нөөцийг бүрдүүлэх үүднээс оюутан сурагчдыг "Оюутны зээлд хамруулж орон нутагт ажиллах боломжийг олгох

1.2.6. Эрүүл мэндийн даатгал голлосон урьдчилан сэргийлэх болон эмнэлгийн тусламж үйлчилгээний хүрээг өргөтгөх бөгөөд эрүүл мэндийн даатгалын цахим картыг нэвтрүүлнэ.

1.2.7. Орон нутгийн иргэд хүссэн үедээ эмийн үнийн хөнгөлөлтийг авах боломжийг бүрдүүлж эмийн үнийн хөнгөлөлтийн зардлын төсвийг нэмэгдүүлэх.

### 1.3. ХҮН АМЫН ХӨГЖИЛ, ХҮН АМЫН ӨСӨЛТ

1.3.1. Хүүхдийн мөнгийг хүн амыг өсгөх бодлого гэж үзэн хүүхэд бүрд ялгаварлалгүйгээр олгодог бодлогоо хэрэгжүүлнэ.

1.3.2. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлнэ.

#### ӨРХ ГЭР БҮЛ

1.3.3. Хүүхдийн ордны барилгыг барих

1.3.4. Хуримын өргөөтэй болох Залуу гэр бүлийг хурмын өргөөндөө албан ёсоор баталгаажуулах.

1.3.5. Ипотекийн зээлийг үргэлжлүүлнэ. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг ипотекийн зээлтэй уялдуулна.

1.3.6. Орон сууцны хороолол, хаус барих аж ахуй нэгж байгууллагын дэмжиж газар дэд бүтцийг шийдвэрлэж өгөх. 1.3.7. Залуу гэр бүл, зорилтот өрхийг орон сууцанд ороход дэмжлэг үзүүлэх.

1.3.7. Хот, хөдөөгийн иргэдээ зээлийн хөнгөлттэй нөхцлөөр хувийн орон сууцтай болгох хөтөлбөр хэрэгжүүлнэ.

#### НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

1.3.8. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний дэргэд Ахмадын амралт сувилалтын төвтэй болох.

1.3.9. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогоор тодорхойлсон олон давхрагат тэтгэврийн тогтолцоог бүрдүүлж, тэтгэвэр аваргын орлогыг эрс нэмэгдүүлнэ.

### 1.4. СОЁЛ, УРЛАГ, СПОРТ

1.4.1. Боржигон чуулгын барилгыг шинээр барьж ашиглалтанд оруулна.

1.4.2. Аймагт Спорт цогцолбор, бассейн, сургалтын төв бүхийн спорт комплекс бий болгох

1.4.3. Баянтал, Шивээговь сумын соёлын төвийг засварлан сайжруулах

1.4.4. Баянтал суманд стандартын спорт заалтай болгох

000000006  
*[Handwritten signatures and stamps]*





1.4.5. Спортын олон улсын хэмжээний томоохон арга хэмжээ, фестиваль, уралдаан, тэмцээнийг зохион байгуулахад орон нутгаас дэмжлэг үзүүлнэ

1.4.6. Олимпын олон төрлөөр өсвөр, залуучууд, насанд хүрэгчдийн үндэсний хэмжээний тэмцээнүүдийг зохион байгуулахад орон нутгаас дэмжлэг үзүүлнэ

1.4.7. Хөнгөн атлетикийн стандартын талбайг байгуулна.

## ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

### 2.1. ӨСӨЛТИЙН БОДЛОГО

2.1.1. 2030 онд нэг хүнд ногдох ДНБ-ийг 10,000 ам.доллар, монгол хүний бодит орлогыг дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээ (нэг хүнд ногдох ДНБ-ний 10 хувь)-д хүргэж, нийт эдийн засгийг 40 тэрбум ам.долларт хүргэх бодлогыг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ. Нийт экспортын хэмжээг 30 тэрбум ам.долларт, түүний дотор уул уурхайн бус салбарын экспортыг 30 хувьд хүргэнэ. 2020-2024 оны хувьд дээрх зорилтыг хангах нөхцөлийг биелүүлэх бөгөөд 2030 онд хүрэх зорилтын 40 хувийг биелүүлсэн байна.

2.1.2. Байгалийн нөөцийн өгөөжийг иргэдийн аж байдлыг сайжруулах, эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийн бүтээн байгуулалт болон хот, хөдөөд эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийг дэмжих тогтвортой олон тулгуурт суурь бий болгоход түлхүү чиглүүлэх бодлого баримтална.

2.1.3. Эдийн засгийн өсөлтийг хангах том төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.

2.1.4. Гангийн үйлдвэр байгуулна

2.1.5. Шивээ-овоогийн нүүрсний үйлдвэрийг түшиглэн нүүрс химийн үйлдвэрийн байгуулна.

#### ЖИЖИГ ДУНД БИЗНЕС

2.1.6. Орон нутгийн онцлогт тохирсон жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэн

2.1.7. Орон нутгийн жижиг дундын үйлдвэрлэлийг дэмжих тусгай сан бий болгох.

2.1.8. Жижиг үйлдвэрлэлийг технологийн шийдлээр дэмжихэд төрөөс анхаарч, хэрэгжүүлэх механизмыг бий болгоно.

2.1.9. Жижиг дунд бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, гарааны бизнесийн гарцыг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээллийн "Биг дата" үүсгэж, нэгдсэн платформ бий болгон аюулгүй байдлыг хангана.

2.1.10. Уламжлалт үйлдвэрлэлтэй холбох Интернет плас SMEs хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.1.11. Төрийн албанаас бизнесийн салбарт шилжиж баялаг бүтээх иргэдийнхээ бизнесийн эхлэлтийн хөрөнгө оруулалтыг жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас санхүүжүүлдэг журамд шилжинэ.

080000007





### САНГИЙН БОДЛОГО

2.1.12. Төсвийг судалгаанд суурилсан төлөвлөлт, сахилга, хэрэгжилт, хяналтыг хангах оновчтой систем бүрдүүлнэ. Судалгааны тинк танк ажиллуулна.

2.1.13. Макро эдийн засгийн уялдааг хангахад чиглэсэн оновчтой бүтэц бий болгоно.

### ТАТВАРЫН БӨДӨЛГӨ

2.1.13. ААНОАТ, НӨАТ, санхүүгийн лизинг, гаалийн болон татварын системийг аж ахуй нэгж, байгууллагыг илүү орлого олох, өргөжин томрох, олон ажлын байрыг бий болгоход нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр хөгжүүлнэ.

### ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

2.1.14. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэн ажлын байрыг бий болгоно.

2.1.15. Бүсийн сургалтуудыг аймагтаа зохион байгуулж бизнес эрхлэгчдийг дэмжин аймгийн эдийн засгийн эргэлтийг сайжруулна.

2.1.16. Төрийн албанаас эрт тэтгэвэртээ гарсан хөдөлмөрлөх чадвартай иргэдийг жижиг дунд, бичил бизнесийн салбарт ажиллах, зөвлөгөө өгөх боломжийг хангаж ажиллана.

### АЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР

2.1.17. Ган, ширэм, зэс, нүүрс-химийн болон газрын ховор элементийг боловсруулах үйлдвэрүүдийг бүс нутгийн нөхцөл, зах зээлийн байдалтай уялдуулж, байгалийн нөөцөд тулгуурлан үе шаттайгаар барьж байгуулна.

2.1.18. Хөдөө аж ахуйн боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, санхүүжилтийн найдвартай тогтолцоо бий болгох, олон улсын стандарт нутагшуулах, экспортлох цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.1.19. Говьсүмбэр аймгийн нутагт эдийн засгийн чөлөөт бүс байгуулж жилд 16 сая тонн нүүрснээс кокс, улмаар 15.0 сая тонн ширэм, ган үйлдвэрлэн экспортлох хар төмөрлөгийн цогцолборыг ашиглалтад оруулахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.

### ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАР

2.1.20. Нүүрс угаах үйлдвэрүүдийг нэмэгдүүлэх

### ДОР ЗОРИЛ

2.1.21. Орон нутгийн авто замын сүлжээг бий болгоно. /Сумдын төвийг хямд өртөгтэй авто замаар аймгийн төвтэй нь холбох ажлыг эхлүүлнэ./

2.1.22. Уул уурхай, ашигт малтмалын ордын бүтээгдэхүүн тээвэрлэх тусгай зориулалтын болон аялал жуулчлалын бүс нутгийг холбосон замыг төр хувийн хэвшлийн түншлэлээр гүйцэтгүүлэх чиглэлийг баримтална.

0800000008



2.1.23. Олон улс чанартай авто замуудыг камержуулж, 150-200 км тутамд зорчигч үйлчилгээний төвүүдийг барина.

2.1.24. Орос Хятадыг холбосон авто зам, төмөр зам, хий дамжуулах хоолой, эрчим хүчний шугам, нефтийн хоолойн бүтээн байгуулалт (2013 оны 3-р сард зарласан Талын зам төсөл)—ыг сэргээн үргэлжлүүлнэ.

2.1.25. Баянтал сумын цэргийн ангийн аер дромыг түшиглэсэн худалдаа, үйлчилгээ, тээвэр логистикийн чөлөөт бүс байгуулна.

2.1.26. Олон улсын автозам төмөр замуудыг түшиглэн тээвэр логистикийн төвүүдийг үе шаттай байгуулна

#### ЭРЧИМ ХҮЧ

2.1.27. Сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг барихад төр хувийн хэвшлийн түншлэлийн зарчмыг түлхүү баримтална.

2.1.28. Аймгийн төвүүдэд дулааны станц, дулааны сүлжээ байгуулах ажлыг хэрэгжүүлж, ашиглалтад оруулна.

#### ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА

2.1.29. Орон нутагт өндөр хурдны интернэтийн сүлжээг өргөтгөж, 5G технологийг нэвтрүүлнэ. Шуудангийн тогтолцоог олон улсын түвшинд хүргэж, хүргэлтийн системийг сайжруулан шуудан түгээлтийг 3 дахин ихэсгэнэ.

2.1.30. Иргэдэд зориулсан цахим боловсролын төвүүдийг байгуулна.

#### БАРИЛГЫН САЛБАР

2.1.31. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг эхлүүлэх замаар хөрсний бохирдлыг эрс бууруулна.

2.1.32. 1000 айлын орон сууц хөтөлбөрийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх / Чойр хотын ерөнхий төлөвлөгөөг тодотгож хаус, таун хаус, хорооллуудыг бий болгох/

#### АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

2.1.33. Гадаад болон дотоод аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор хувийн хэвшилт суурилсан кемп баазуудыг бий бодлогоор дэмжих

#### ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

2.1.34. Малыг стандарт шаардлагын дагуу үйлдвэрийн аргаар бойлж лабороторийн шинжилгээнд хамруулж худалдаанд гаргах

2.1.35. Хүнсний хяналтын тогтолцоог орчин үеийн ухаалаг технологид тулгуурлан төгөлдөржүүлж, хүнсний бүтээгдэхүүний бүх лабораторийг мэргэжлийн холбоод болон хувийн хэвшилд шилжүүлнэ.

080000009





## **ГУРАВ. ЭЗЭН ГОВЬСҮМБЭР**

### **3.1. ХОТ, ХӨДӨӨГИЙН ТЭНЦВЭРТЭЙ ХӨГЖИЛ**

#### **БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ**

3.1.1. Хөгжлийн тэргүүлэх чиглэлийн салбараа тодорхойлж, хөгжлийн бодлогоо уялдуулан хамтарч хөгжихийг дэмжиж, дэд бүтцийн барилга, байгууламж, тээвэр, логистикийн сүлжээг бий болгоно.

### **3.2. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ**

3.2.1. Байгалийн баялгаас улсын төсөвт орж байгаа орлогын 30 хүртэлх хувийг орон нутаг нь шууд хуваарилдаг тогтолцоог бүрдүүлнэ.

#### **ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ "ШИНЭ СУМ" ТӨСӨЛ**

3.2.2. Сумын төвийг дахин төлөвлөж, ногоон байгууламж, дэд бүтэц, барилга байгууламж бүхий орчин үеийн сууриныг хөгжүүлнэ. Сумын шинэчлэлийг иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ.

### **3.3. МАЛ АЖ АХУЙ**

3.3.1. Малын бэлчээр сүйтгэг үлийн цагаан оготныг усгах ажлыг үе шаттай зохион байгуулна.

3.3.2. Хөдөөгийн малчин өрхийг дэмжин "Малжуулах хөтөлбөр"-ийг орон даяар хэрэгжүүлнэ.

3.3.3. Бэлчээр усжуулах гүн өрмийн худгийг нэмэгдүүлэх

### **3.4. ГАЗАР ТАРИАЛАН**

3.4.1. Өвлийн хүлэмж байгуулах Аж ахуй нэгж иргэний дэмжинэ

3.4.2. Газар тариалангийн үйлдвэрлэлийн мэргэжлийн ажиллах хүчний хангамж, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.

### **3.5. ЧОЙР ХОТЫН ХӨГЖИЛ**

#### **ЧОЙР ХОТ**

3.5.1. Гэр хорооллыг инженерийн дэд бүтэц /цэвэр ус, бохир ус ариутгах татуурга, интернэт шилэн кабель/-д холбож, халаалтыг төвлөрсөн болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлж, амьдран суух байшингаа барихад нь урт хугацаатай, хүү багатай, орон сууцны ипотекийн зээлээр санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллана.

3.5.2. Иргэд өөрийн өмчилж авсан хашааны газар дээр айл, хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийж, инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон, амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлж, амьдран суух байшингаа барихад нь урт хугацаатай, хүү багатай, орон сууцны ипотекийн зээлээр санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллана.

0800000010  
*[Handwritten signatures and stamps]*



3.5.3. Гэр хорооллын дахин төлөвлөлтөөс чөлөөлөгдсөн газар дээр иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх, эрүүл амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цэцэрлэгт хүрээлэнгүүдийг байгуулна

3.5.4. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, хог боловсруулах, буцаан ашиглах үйлдвэр байгуулж, иргэд хогоо ангилан ялгаж тушаах

3.5.5. Сургуулийн автобус ажиллуулж, хүүхдийн сургуульдаа аюулгүй ирж, буцах нөхцөлийг бүрдүүлнэ

3.5.6. Хотын соёлын өв, дурсгалт барилгуудыг нураахгүйгээр, арчлан хамгаалах, сэргээх завсарлах хэлбэрээр сайжруулан соёлын өвийг хойч үедээ үлдээж ажиллана

3.5.7. Дугуйн болон явган замын сүлжээг илүү нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын гаднах авто машины зогсоолыг бий болгох

3.5.8. Дулааны цахилгаан станц байгуулна

3.5.9. Цэвэрлэх байгууламж байгуулна

3.5.10. Хөдөө, орон нутагт нам даралтын зуухнуудыг татан буулгаж, нэгдсэн системд холбоно.

## **ДӨРӨВ. АЮУЛГҮЙ АМГАЛАН ГОВЬСҮМБЭР**

### **4.1. БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО**

4.1.1. Оюутан цэрэг хөтөлбөрийг үргэлжлүүлж хэрэгжүүлнэ.

### **4.2. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ ЭКОСИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ**

4.2.1. “Саарал” усыг дахин ашиглах, түүнд олгох урамшууллын тогтолцоог бий болгоно.

4.2.2. Ойжуулах, ойг цэвэрлэх, нөхөн сэргээх асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, шинэ технологи нэвтрүүлнэ.

4.2.3. Ой, рашаан, булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжийг орон нутгаас урамшуулна.

#### **БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**

4.2.4. Орчноо ногооруулсан иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.

000000011  
*[Handwritten signatures and stamps]*